



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/88

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.1.17, 33 дугаар зүйлийн 33.1, 33.1.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам"-ыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ахлагч:	Ж.Ганбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Ж.Гантулга	Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга
	Д.Баярмаа	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга
	Г.Нямхатан	Хэнтий аймаг дахь Политехникийн коллежийн захирал
	Б.Энхзаяа	Ажил олгогч эздийн холбооны дарга
	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Мөнхжаргал	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Д.Оюунжаргал	Хүнс, хөдөө аж ахуйн газрын Жижиг дунд үйлдвэрлэл, зээлийн батлан даалтын сан хариуцсан мэргэжилтэн
	М.Ганхүлэг	Аймгийн Иргэдийн Хурлын төлөөлөгч
Нарийн бичгийн дарга:	Г.Лхагвахатан	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

2. Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх ажлыг батлагдсан журмын дагуу төлөвлөн зохион байгуулж, тайланг жил бүр аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010257